



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Лоялти солюшн” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Э.Нарантунгалаг, Э.Буян-Өлзий нар өөрсдийн эзэмшлийн нийт 20'000'000.00 /хорин сая/ төгрөгийн үнэ бүхий 400 /дөрвөн зуун/ ширхэг хувьцааг иргэн Б.Мөнгөнчимэгт шилжүүлсэн тул хавсралтад заасан өөрчлөлтийг бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Лоялти солюшн” ХХК /Э.Буян-Өлзий/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 4 дүгээр сарын 24-ний
өдрийн 67 дугаар тогтоолын хавсралт



“ЛОЯАЛТИ СОЛЮШН” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 50,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцаан ы тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 50,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Э.Нарантунгалаг /ЖЮ82042004/	200	10,000,000.00	50%	-	-	10,000,000.00	-	-	-
2	Э.Буян-Өлзий /ЧП83020469/	200	10,000,000.00	50%	-	-	10,000,000.00	-	-	-
3	Б.Мөнгөнчимэг /АМ79012000/	-	-	-	400	20,000,000.00		400	20,000,000.00	100%
	Нийт	400	20,000,000.00	100%	400	20,000,000.00	20,000,000.00	400	20,000,000.00	100%